

## САЛХИТЫН ИЛ УУРХАЙН ХӨРСНИЙ ЧУЛУУЛАГ БОЛОН ХҮДЭР БУТЛАХ ӨРӨМДЛӨГ, ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Д/д	Тодорхойлолт	Тайлбар
1	<b>Ажил гүйцэтгэх үндэслэл:</b>	“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Салхитын уулын баяжуулах үйлдвэрийг технологийн шаардлага хангасан бүхэллэг бүхий хүдрээр хангахад шаардагдах хүдэр олборлох, уулын ажил явуулахад хөрс болон хүдэр бутлах Өрөмдлөг, тэсэлгээний ажил хийж гүйцэтгэнэ
2	<b>Захиалагч байгууллага:</b>	“Эрдэнэс алт ресурс” ХХК
3	<b>Төслийн байршил</b>	“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхит” нэртэй ордын ил уурхай дээр
4	<b>Гэрээт ажлын зорилго, үр дүн</b>	<p><b>Зорилго:</b> “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Салхитын ордын ил уурхай дээр “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хууль, “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Эрдэнэс Алт Ресурс” компанийн “Тэсэлгээний ажил гүйцэтгэх журам”, “Тэсэлгээний ажлын горимууд”, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхитын мөнгөний ордын ил уурхайн хөрсний чулуулаг болон хүдрийн Өрөмдлөг, тэсэлгээний ажлаар стандартын шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, дэвшилтэд технологиор тэсэлгээний ажлыг мэргэжлийн өндөр түвшинд аюул осолгүй бутлан сийрэгжүүлэх ажил хийж гүйцэтгэхэд энэхүү ажлын зорилго оршино.</p> <p><b>Үр дүн:</b> Ил уурхайн хөрс хуулалт хүдэр олборлолтын ажлыг батлагдсан ТЭЗҮ болон зураг төсөл, ажлын төлөвлөгөө, захиалагч талын өгсөн чиглэл, зааварчилга болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны стандарт, дүрэм, журмын дагуу баяжуулах үйлдвэрийг хүдрээр хангах ажлыг таслахгүй явуулах ба ингэхдээ хүдрийн бутлагдлын хэмжээг 400 мм-ээс ихгүй болгож бутлан сийрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ</p>
5	<b>Гүйцэтгэх ажил</b>	<p><b>Өрөмдлөг, тэсэлгээний ажил:</b></p> <p>Ордын уул геологийн нөхцөл, чулуулгийн тогтоц, шинж чанараа с шалтгаалан хөрсөнд жилийн дөрвөн улирлын турш Өрөмдлөг, тэсэлгээний ажлыг явуулах шаардлагатай. Хүдрийн хатуулаг нэмэгдэх, бүхэллэгийг багасгах зорилгоор Өрөмдлөг, тэсэлгээний ажил хийж бутлан сийрэгжүүлнэ.</p> <p>1.1 Гүйцэтгэсэн Өрөмдлөг, тэсэлгээний ажил нь стандартын шаардлага хангаагүйгээс тэслэгдсэн уулын цул овор хэмжээ томтой, үр дүнгүй болж Захиалагч талд хохирол учирсан бол түүнийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж асуудлыг шийдвэрлэнэ. Шаардлага хангаагүй Өрөмдлөг, тэсэлгээний ажилд гарсан зардлыг Захиалагч тал хариуцахгүй болно.</p> <p>1.2 Гүйцэтгэгч нь өөрийн Өрөмдлөг, тэсэлгээний инженертэй байх ба Өрөмдлөг, тэсэлгээний ажлын паспортыг захиалагч</p>

		<p>компанийн инженерээр батлуулан өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэнэ.</p> <p>1.3 Салхит уурхайн ТЭЗҮ-д заагдсаны дагуу Өрмийн хошууны диаметр 140мм болон 127мм байна. Торлол 3x3.5 4x4.5 байна.Уулын нөхцөл байдлаас шалтгаалан захиалагч тал торлогын хэмжээг өөрчилж болно.</p> <p>1.4 Захиалагч талын инженерийн өгсөн үүрэг даалгавар, технологийн шаардлагыг биелүүлж ажиллана.</p> <p>1.5 Хүдрийн блокт ажиллах өрмийн машин нь хаягдал шламаар дээжлэлт хийх боломжтой, мөн дээж авагчтай байна.</p> <p>1.6 Захиалагч талын инженерийн өгсөн зааварчилгааны дагуу өнцгийн хазайлттай өрөмдөх өрмийн машинтай байна.</p> <p>1.7 Өрөмдлөгийн ажил, цооног цэнэглэлтийн ажилд захиалагч тал хяналт тавих буюу ажил гүйцэтгэлийн явцад захиалагч талыг төлөөлж буй төлөвлөлтийн инженер шууд оролцох эрхтэй байна.</p> <p>1.8 Гүйцэтгэгч нь “Эрдэнэс Алт Ресурс” компанийн уурхайд Өрөмдлөг, тэсэлгээний ажлыг явуулах ба ингэхдээ хүдрийн бутлагдлын хэмжээг 400 мм-ээс ихгүй болгож бутлан сийрэгжүүлэх үүргийг хүлээнэ.</p> <p>1.9 Өрөмдлөг, тэсэлгээний ажлыг уурхай дээр гүйцэтгэгч нь ажил үүргээ аюул осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна.</p> <p>1.10 Тэсэлгээний ажлаас шалтгаалан хүдрийг бохирдуулсан тохиолдолд захиалагч болон гүйцэтгэгч талаас хамтарсан акт үйлдэж, тухайн хүдрийг нээхэд хуулсан хөрсний өртөг, бохирдсон хүдрийн үнээр тооцон тэсэлгээний ажлын гүйцэтгэлээс хасаж тооцно (Уурхайн ашиглалтын геологи хүдрийн биетийн хүрээ тавьж акт үйлдэнэ).</p> <p>1.11 Уулын ажлын төлөвлөгөөг захиалагч талаас сар сараар гаргана. Тухайн сарын төлөвлөгөөг сар эхлэхэд захиалагч тал боловсруулж баталсан байна.</p> <p>1.12 Хөрсний чулуулаг тэслэх тэсрэх бодисын хувийн зарцуулалт нь 0.40 – 0.47 кг/м3 хооронд, хүдрийн чулуулаг тэслэх тэсрэх бодисын хувийн зарцуулалт нь 0.60 – 0.70 кг/м3 хооронд тус тус хэрэглэхээр төлөвлөнө (тэсрэх бодисын хувийн зарцуулалтыг 2 тал харилцан тохиролцоно).</p> <p>1.13 Хөрсний чулуулгийн бутлагдлын чанарыг сайжруулах, чулуулгийн шилжилт, хөрсний тархалтыг багасгах, тэсэлгээний улмаас гарах аюул, ослыг багасгахын тулд тэсэлгээний хэрэгслийг хором удаашруулсан үйлчилгээтэй чанар сайтай тэсрэх бодис үйлдвэрийн алдаа багатай тэслэх хэрэгслийг сонгон ажиллах.</p> <p>1.14 Тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн нөөцийг 15 хоногоор татна.</p> <p>1.15 Уулын ажлуудыг гүйцэтгэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд баримтлан ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн системийг боловсруулан, захиалагчаар батлуулж, гэрээт хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.</p>
--	--	--

		<p>1.16 Уурхайн технологийн ажлуудад зориулан аюулгүй ажиллагааны журам, горим боловсруулан Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай эрсдэлийн үнэлгээг хийсэн байна. Мөн үйл ажиллагаандаа OSHAS 18001 стандартыг нэвтрүүлж ажиллах бөгөөд шаардлагатай ажлууд дээр дутуу дүрэм журмыг боловсруулан захиалагчаар батлуулж, мөрдөж ажиллана.</p> <p>1.17 Ажлын гүйцэтгэлийн явцад гарсан технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдол гарсан тохиолдолд захиалагч талд мэдэгдсэний дагуу заасан хугацаанд арга хэмжээ авч, үр дүнг захиалагч талд танилцуулж, зөвшөөрөл авсны дараагаар хэвийн үйл ажиллагааг эхэлнэ.</p> <p>1.18 Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны ажилтнуудыг ажлын талбайд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.</p> <p>1.19 Гүйцэтгэгч талын инженерүүд төлөвлөсөн блокийн хүрээнд тэсэлгээний ажил хийгдэх цооног төлөвлөлтийг зориулалтын программ хангамжийн тусламжтайгаар хийж гүйцэтгэнэ. Мөн ил уурхайн ажлын бус хажуу, аюулгүйн бермийг дизайны дагуу үүсгэх тэсэлгээний арга аргачлал ашиглан тэсэлгээний ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>1.20 Тэсэлгээний ажлаас үүссэн аюулгүйн догол цөмрөх, хананд овор үлдэх тохиолдолд тухайн асуудлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна. Тэсэлгээний цооногийн төлөвлөлтөд захиалагч нь санал өгөх эрхтэй байна.</p> <p>1.21 Цооногийн түгжээсийг зориулалтын шаардлага хангасан материалаар хийнэ.</p> <p>1.22 Улиралд 1-2 удаа цаг агаар, тэсэлгээний ажлын нөхцөл байдал, чулуулгийн шинж чанараас хамаараад тэсэлгээний ажлын чанарыг сайжруулах, ил уурхайн ажлын бус доголын хүрээг дизайны дагуу үлдээх зэрэг чиглэлд шинэ арга, технологи, шийдлийг нэвтрүүлж байх.</p> <p><b>1.23</b> Гүйцэтгэгч тал нь ордын ан цавшил хагарал, шаварлаг үе, чулуулгийн бат бөхийн шинж чанар зэрэг уул, геологийн нөхцөл байдал хүндрэлээс хамаарсан тэсэлгээний цохилтын энерги алдалтаас хүдэр, чулуулгийн овор гарах нөхцөл үүссэн үед тухай бүрд захиалагч талд мэдэгдэх хамтран шийдэл гаргах.</p> <p><b>Уурхайн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах</b></p> <p>2.1 Ухаж ачих боломжтой тэслэгдсэн материалын хамгийн бага хэмжээг 4 хоног байлгах.</p> <p>2.2 Цаг агаарын саатал, өвлийн улиралд хүрэлцэхүйц хэмжээний тэсрэх бодис, тэслэх хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх.</p> <p>Цаг агарын саатал, өвлийн улиралд ажиллахад хүрэлцэхүйц хэмжээний өрөмдлөгийн сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлсэн байх.</p>
--	--	--

		2.3 Ордод мэргэжлийн байгууллагаар гүйцэтгэсэн гео-техникийн судалгааны ажлын дүгнэлт зөвлөмжийг мөрдөж ажиллах.
6	<b>Ажиллах хүч</b>	<p>3.1 Гүйцэтгэгч нь Өрөмдлөг, тэсэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын баг, ажиллах боловсон хүчээр бүрэн хангагдсан байна.</p> <p>3.2 Гүйцэтгэгч нь уул уурхайн болон өрөмдлөг, тэсэлгээний чиглэлийн мэргэжлийн сургалтад бүрэн хамрагдсан хүчин төгөлдөр тэсэлгээчний нэгдсэн үнэмлэхтэй, тэсрэх материалтай харилцах эрхтэй инженер техникийн ажилчдын баг бүрэлдэхүүнтэй байна.</p> <p>3.3 Гүйцэтгэгч нь байнга байх дараах голлох боловсон хүчинтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Өрөмдлөг, тэсэлгээний инженер тэсэлгээний ажлын удирдагч 2 хүн (4 –өөс доошгүй жилийн туршлагатай)</li> <li>• Тэсэлгээчин 4 хүн (2–оос доошгүй жилийн туршлагатай)</li> <li>• Тэсрэх материалтай харьцах эрхтэй туслах ажилтан, жолооч 4 хүн (2–оос доошгүй жилийн туршлагатай)</li> <li>• Нярав 2 хүн тэсрэх материалтай харьцах эрхтэй, (1–ээс доошгүй жилийн туршлагатай)</li> <li>• Өрмийн машины оператор 6 хүн</li> <li>• Өрмийн мастер 2 хүн</li> <li>• Хабза мэргэжилтэн 2 хүн</li> </ul>
7	<b>Техникийн шаардлага</b>	<p>4.1. Гүйцэтгэгч нь 3-аас доошгүй жилийн ажлын дадлага, туршлагатай, өмнө нь ижил төрлийн уурхайн хөрсний чулуулаг болон хүдрийн Өрөмдлөг, тэсэлгээний ажил, үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх.</p> <p>4.2. Хүдэр тэсэлгээний явцад овортой хүдэр гаргасан тохиолдолд хүдрийн бутлагдлын хэмжээг 400 мм-ээс ихгүй байхаар бутлан сийрэгжүүлэх чадамжтай техниктэй байна.</p> <p>4.3. Гүйцэтгэгчийн баг бүрэлдэхүүн нь (Уурхайн тэсэлгээний ажил гүйцэтгэх ажилтнууд нь) ажил үүргээ аюул, осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах тоног төхөөрөмж, ажлын багаж, төхөөрөмж хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан байна.</p> <p>4.1. Цаг ашиглалт болон техникийн бэлэн байдлыг 85-аас доошгүй хувьтай байлгана.</p> <p>4.2. Гэрээний хугацаанд ХАБЭА, БО-ны холбогдолтой хууль, дүрэм, журам зөрчигдсөнөөс үүдэлтэй бүтээлийн алдагдал, цаг хугацаатай холбоотой аливаа хохирлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцах чадвартай байх.</p> <p>4.3. Өрөмдлөг, Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдаалах, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөлтэй байх.</p> <p>4.4. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу боловсруулсан дүрэм журмуудтай байх.</p> <p>4.5. Тэсэлгээний ажлыг гүйцэтгэх ажилтнууд нь ажил үүргээ аюул, осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах</p>

		<p>машин, тоног төхөөрөмж, ажлын багаж, хувцас, хамгаалах хэрэглэлээр бүрэн хангагдсан байна.</p> <p>4.6. ХАБЭА, Байгаль орчны тухай хуулийн дагуу Гүйцэтгэгчийн бүх ажилтан ажиллагсад өөрийн компанийн аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгаанд бүрэн хамрагдсан, уурхайн талбайд аюулгүй ажиллах ойлголт мэдлэгтэй, түүнийг нотолсон сургалтад хамрагдсан бүртгэлийн хуудастай байна.</p> <p>4.7. Ажил гүйцэтгэгч тал ХАБЭА-н мэргэжилтэн ажиллуулна.</p> <p>4.8. Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтэс /цаашид ХАБЭАБО-н хэлтэс/-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байх бөгөөд сар, улирал, жилийн төлөвлөгөөг болон тайланг захиалагч талын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэст /цаашид ХАБЭАБОХ/ мэдээллийг хүргүүлэн ажиллана.</p> <p>4.9. Мэргэжлээс шалтгаалах өвчний / цаашид МШӨ гэх/ талаар нийт ажилтнуудад судалгааг хийж захиалагч талд мэдээллийг хүргүүлэн ажиллана.</p> <p>4.10. ХАБЭА-н тухай хуулийн дагуу ХАБЭА-н сургалтын хөтөлбөрийг боловсруулан захиалагч талд мэдээллийг өгөх ба нийт ажилтны сургалт зохион байгуулсан талаарх мэдээллийг хүргүүлэн ажиллана.</p> <p>4.11. Захиалагч талаас нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан талаар мэдээллийг хүргүүлэн ажиллах ба уурхайн эмчид мэдээллийг өгч өдөр тутмын эрүүл мэндийн талаарх ажлын тайланг хүргүүлэн ажиллана.</p> <p>4.12. Уурхайн технологийн ажлуудад зориулан аюулгүй ажиллагааны журам, горим боловсруулан Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийсэн байна. Мөн үйл ажиллагаандаа MNS ISO 45001 стандартыг нэвтрүүлж ажиллах бөгөөд шаардлагатай ажлууд дээр дутуу дүрэм, журам, аюулгүй ажиллагааны заавруудыг боловсруулан захиалагчаар батлуулж, мөрдөж ажиллана.</p> <p>4.13. Ажил гүйцэтгэгч талын Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс нь осол, осол дөхсөн тохиолдлуудын талаар үнэн бодитоор мэдээлж ажиллах ба үйлдвэрлэлийн осол, осол дөхсөн тохиолдлуудын судалгааг хийж захиалагч талд мэдээллийг нуун дарагдуулалгүй хүргүүлэн ажиллана.</p> <p>4.14. Ажил гүйцэтгэгч тал өдөр тутам ажлын байранд аюулыг мэдээлэх хуудсыг ажилтнуудаар бөглүүлэн аливаа учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ХАБЭАБО-н хэлтэст мэдээллийг хүргүүлэн ажиллана.</p> <p>4.15. Ажил гүйцэтгэгч тал нийт ажилтнуудад нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай хувцсыг ХАБЭА-н тухай хуулийн дагуу ажилтнууддаа олгож ажиллана.</p> <p>4.16. Ажил гүйцэтгэгч тал ажлын байранд эрсдэлийн үнэлгээг хийж захиалагч талын ХАБЭАБО-н хэлтэстэй хамтран ажиллана.</p>
--	--	--

		<p>4.17. Ажил гүйцэтгэгч тал ажлын байран дах аюултай нөхцөл байдлыг захиалагч талын ХАБЭАБО-н хэлтэст болон Салхит уулын баяжуулах үйлдвэрийн удирдлагуудад мэдээллийг шуурхай мэдээлж ажиллана.</p> <p>4.18. Ажил гүйцэтгэгч тал захиалагч талын дотоод журмын дагуу ил уурхайн олборлолтын бүсэд замын хөдөлгөөнд оролцох автомашин, өөрөө явагч машин механизмуудыг бүрэн бүтэн байдлыг хангуулан, богино долгионы станц, туг, маяк, LV, SV, туслах техникүүд болон хүнд даацын тээврийн хэрэгсэл, машин механизмуудад парк дугаарууд, суурин станцыг суурилуулан байршуулсан байна.</p> <p>4.19. Ажлын гүйцэтгэлийн явцад гарсан технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдол гарсан тохиолдолд захиалагч талд мэдэгдсэний дагуу заасан хугацаанд арга хэмжээ авч, үр дүнг захиалагч талд танилцуулж, зөвшөөрөл авсны дараагаар хэвийн үйл ажиллагааг эхэлнэ.</p> <p>4.20. Захиалагч талаас шаардах Ил уурхайн олборлолтын бүсэд гэрэл гэрэлтүүлэг, замын болон бусад тэмдэг тэмдэглэгээг байршуулан ажиллах шаардлагатай.</p> <p>4.21. Ажил гүйцэтгэгч тал галын аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба гал, гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж ажиллана. Мэдээллийг захиалагч талд хүргүүлэн ажиллана.</p> <p>4.22. Ажил гүйцэтгэгч тал нийт автомашин, өөрөө явагч машин механизмуудын галын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх шаардлагатай.</p> <p>4.23. Ил уурхайн олборлолтын бүсэд болон засварын хэсэг, ажилчдын кемп, ажлын байруудад галын аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулах, захиалагч талаас гал, гамшгийн сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд хамран ажиллана.</p> <p>4.24. Захиалагч талаас ХАБЭА-н I, II, III, IV-р шатны хяналт зохион байгуулах ажлын хүрээнд үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулан ажиллах шаардлагатай.</p> <p>4.25. Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны /Цаашид ХАБЭАБО гэх/ ажилтнуудыг ажлын талбайд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.</p> <p>4.26. ХАБЭАБО-ны талаарх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамж уулахгүй, давхар гэрээлэхгүй.</p> <p>Гүйцэтгэгчийн бүх тээврийн хэрэгслүүд түүнийг ажиллуулах тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан байна.</p> <p>4.27. Өрөмдлөг, тэсэлгээний ажлыг гүйцэтгэх шаардлагатай техник хэрэгсэл, машин механизмаар бүрэн хангагдсан байна. Уулын ажлын төлөвлөгөө, зураг төсөл, Уурхайн уулын ажлын горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн уулын ажил хийх хангалттай</p>
--	--	---

		<p>хүчин чадалтай, иж бүрэн үндсэн тоног төхөөрөмжүүдтэй байна. Үүнд:</p> <p>4.28. Тэсрэх материал тээвэрлэх машин – 2 /тусгай зориулалтын/  4.29. ЭНТБ холин цэнэглэгч машин – 1 /тусгай зориулалтын/  4.30. Үйлчилгээний машин - 1  4.31. 105-168 мм диаметртэй 12м хүртэл өрөмдөх, өнцгийн хазайлттай өрөмдлөг хийх боломжтой, хүдрийн биетээс геологийн дээжлэлт авч болохоор тоноглогдсон тэсэлгээний өрөм - 3 ширхэг</p> <p><b>4.32. Цахилгаан хангамж:</b></p> <p>a. Ажилчдын болон өөрсдийн байрлах кемп, офис объектуудынхаа цахилгаан хангамж шугам сүлжээний ашиглалтыг хариуцан үзлэг шалгалт, засвар үйлчилгээг хийж хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах.  b. Сар бүр хэрэглэсэн эрчим хүчний хэрэглээгээ тоолуураар тооцон гаргасан акттай танилцаж тооцоо хийх.  c. Ашиглалтын үеийн засвар үйлчилгээний багаж, тоног төхөөрөмж, сэлбэг материалууд, нөөц материалуудаа төсөл хэрэгжүүлэгч хариуцаж ажиллах.</p> <p><b>4.33. Байгаль орчин:</b></p> <p>a. Уурхайн тэсэлгээний үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлыг устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж, устгах ажлыг зохион байгуулах  b. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн эдэлбэр газарт мод тарих ажлыг зохион байгуулах  c. Байгаль орчинтой холбоотой олон нийтийн ажилд идэвхтэй оролцох  d. Хог хаягдлын тухай хууль, байгаль орчны тухай хууль болон дотоод журмын хүрээнд сар, хагас жил, жилийн аюултай хог хаягдлын бүртгэл судалгааг хийж тайланг боловсруулж баталгаажуулах</p>
8	<p><b>Дэд бүтэц төлбөр тооцоо</b></p>	<p>Тэсэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай машин техник, тоног төхөөрөмжийг засварлах засварын мэргэжлийн баг бүрэлдэхүүнтэй, ажлын байр, ахуй хангамжтай холбоотой асуудлыг стандартын дагуу, бүрэн шийдвэрлэх чадамжтай байна.</p> <p>Нийт тэсэлгээ хийх уулын цул 2,500,000 м3 байна.</p> <p>Тухайн онд өрөмдөж тэслэх уулын цулын 80% нь устай, 20% нь хуурай байх учир тэсрэх бодисыг үүнтэй уялдуулан татна.</p> <p>Тэслэгдсэн уулын цулын хэмжээг тооцохдоо дараах аргачлалыг ашиглана:</p> <p>4.10.1.Төлөвлөгдсөн блокийн уулын цулын хэмжээг доорх аргачлалаар тооцно:  Эгнээ хоорондын зай – а</p>

		<p>Цооног хоорондын зай – b  Цооногийн дундаж гүн – l цооног  Нийт цооногийн тоо - n цооног  <math>Q=a*b*l*n</math>, м3</p> <p>4.10.2. Тэслэгдэхээс өмнөх болон тэслэгдсэн блокийн ухаж ачсаны дараах маркшейдерийн хэмжилтийг харьцуулж уулын цулыг тооцно.</p> <p>Гэрээний 5.2-д заасан нийт ажлын талбайд хийгдэх ажил нь төлөвлөгөөний дагуу явагдах ба төлөвлөгөөт хэмжээ нь өөрчлөгдөж болох бөгөөд энэ тохиолдолд ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан актыг үндэслэн төлбөрийг тооцно.</p> <p>Тэсэлгээний ажлыг сар бүрийн 01-ний өдрөөр 2 талын маркшейдерийн хэмжилтээр дүгнэх ба уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажлын талбай ул, овор ихтэй чулуулгийн хэмжээ 1.7-т заасан шаардлагын дагуу хүлээн авч, тооцоо хийгдэнэ.</p> <p>Захиалагч тал нь гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүнг сар бүр актаар хүлээн авна.</p>																															
9	Ажлыг гүйцэтгэх хугацаа	<p style="text-align: center;"><b>Тэслэх уулын цулын хэмжээ:</b></p> <table border="1" data-bbox="552 927 1453 1037"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Сар бүр</td> <td>м3</td> <td>208,400</td> </tr> <tr> <td>Сар бүр</td> <td>Тууш.м</td> <td>11,574</td> </tr> </tbody> </table> <p>Салхитын ил уурхайн уулын ажлын 2024 оны төлөвлөгөө:</p> <table border="1" data-bbox="552 1104 1453 1350"> <thead> <tr> <th>№</th> <th>Үзүүлэлтүүд</th> <th>Хэмжих нэгж</th> <th>2024 оны төлөвлөгөө</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Нийт уулын цул</td> <td>мян.м3</td> <td>208,400</td> </tr> <tr> <td rowspan="2">2</td> <td rowspan="2">Хүдэр олборлолт</td> <td>мян.тн</td> <td>50,000</td> </tr> <tr> <td>мян.м3</td> <td>18,726</td> </tr> <tr> <td>3</td> <td>Эзлэхүүн жин</td> <td>т/м3</td> <td>2.67</td> </tr> <tr> <td>4</td> <td>Херс хуулалт</td> <td>м3</td> <td>189,274</td> </tr> </tbody> </table> <p>Гэрээт ажлыг 12 сараар хийж гүйцэтгэнэ</p>	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Сар бүр	м3	208,400	Сар бүр	Тууш.м	11,574	№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө	1	Нийт уулын цул	мян.м3	208,400	2	Хүдэр олборлолт	мян.тн	50,000	мян.м3	18,726	3	Эзлэхүүн жин	т/м3	2.67	4	Херс хуулалт	м3	189,274
Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ																															
Сар бүр	м3	208,400																															
Сар бүр	Тууш.м	11,574																															
№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө																														
1	Нийт уулын цул	мян.м3	208,400																														
2	Хүдэр олборлолт	мян.тн	50,000																														
		мян.м3	18,726																														
3	Эзлэхүүн жин	т/м3	2.67																														
4	Херс хуулалт	м3	189,274																														
10	Бусад шаардлага	<p>5.1. Тэсэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай аливаа тусгай зөвшөөрөл авах, сум орон нутагтай гэрээ байгуулах, орон нутгийн засаг захиргаанаас тушаал шийдвэр гаргуулах, газар ус болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл авах зэрэг асуудлыг гүйцэтгэгч тал хариуцах бөгөөд ийнхүү хийгээгүйгээс гарсан аливаа хохирлыг Захиалагч тал болон бусад талууд хариуцахгүй.</p> <p>5.2. Гүйцэтгэгч нь Салхитын уулын баяжуулах үйлдвэрийн ил уурхайн тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс тэсэлгээний материалын 4 сарын нөөцийн үлдэгдэлтэй байна. Салхитын уурхайг хангах тэсэлгээний материалын үлдэгдэл нөөц 4 сар /832 мян.м3/ -ын уулын ажлыг тэслэх хэмжээнээс багассан тохиолдолд ил уурхайн инженерт албан байдлаар бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү үүргээ биелүүлээгүйн улмаас захиалагч талд хохирол учруулсан тохиолдолд гүйцэтгэгч талаас учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.</p>																															



		<p>5.3. Захиалагч нь урьдчилан мэдэгдсэний дүнд уулын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд уурхайд сул зогсолт хийлгэх эрхтэй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.</p> <p>5.4. Өрөмдлөг, тэсэлгээний ажил дутуу хийгдэж мөрөгцөгийн ул төлөвлөсөн түвшинд хүрээгүй эсвэл илүү гарсан болон өрөмдсөн цооног тэсрээгүй тохиолдолд захиалагч тал болон бусад талууд төлбөрийн хариуцлага хүлээхгүй.</p> <p>Давагдашгүй хүчин зүйл (УИХ, Засгийн газрын шийдвэр, Хууль тогтоомжийн өөрчлөлт, ажил хаялт, эдийн засгийн хямрал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр, үер усны гамшиг болон бусад байгалийн гамшигт үзэгдэл, гадаад худалдааны хорио цээр болон экспорт, импортын хориг, терроризм, бусад багцын ХАБ-ын зөрчил)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч болон гүйцэтгэгч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.</p>
--	--	--